

СОЁМБО МЭДЭЭ

ЗАСГИЙН ГАЗАР

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БОЛОН СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААРХ ЦАХИМ СУРГАЛТ БОЛЛОО



ЗХЖШ-ын Холбоо мэдээлэл, технологийн хэлтэс, Мэдээллийн аюулгүй байдлын алба, Хэвлэл мэдээллийн алба хамтран Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын удирдлага болон нууц хадгалалт, хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан албан тушаалтан, орон тооны бус хэвлэлийн төлөөлөгч нарыг хамруулсан цахим сургалтыг энэ сарын 15-нд зохион байгууллаа.

Хурлын эхэнд Мэдээллийн аюулгүй байдлын албаны мэргэжилтэн, дэд хурандаа Х.Батжаргал ЗХЖШ-ын даргын тушаалаар батлагдаад удаагүй байгаа Зэвсэгт хүчний Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмын талаар мэдээлэл өгч, бие бүрэлдэхүүнээ мөрдүүлэхэд хэрхэн анхаарч ажиллах талаар яриллаа. Тухайлбал, Зэвсэгт хүчний мэдээллийн аюулгүй байдлыг хангахад цэргийн алба хаагчид ямар үүрэг хүлээсэн байдаг, нууцтай танилцах албан тушаалтан хэн хэн байх талаар дурдаж, нээлттэй, нийтэд нээлттэй мэдээллийн ялгааг тайлбарлав. Нээлттэй гэдэг нь зөвхөн тухайн байгууллагын дотоод мэдээлэл буюу гадагшаа задруулах шаардлагагүй мэдээлэл, нийтэд нээлттэй гэдэг нь олон нийтэд мэдээлэл

боломжтой, мэдээлснээрээ ямар нэгэн хохиролгүй бөгөөд энэ нь сурталчилгааны чиглэлийнх байдаг гэлээ. Үргэлжлүүлэн Холбоо мэдээлэл, технологийн хэлтсийн дарга, хурандаа М.Золзаяа сүүлийн үед техник, технологийн дэвшлийг ашиглаж, залуус социал орчинд идэвхтэй байх болсон. Зэвсэгт хүчний дийлэнх олонхийг залуучууд эзэлдэг учраас тэд ч ялгаагүй тодорхой цагийг цахим орчинд өнгөрөөж байгаа. Гэхдээ цэргийн алба хаагчид төрийн болон албаны нууц, анги, байгууллагынхаа бүтэц, орон тоо, байрлал, байлдааны дугаартай зэвсэглэл, техникийн тухай мэдээллийг хувийнхаа социал хаяг дээр байрлуулахыг хатуу хориглоно. Хэрэв байрлуулбал хариуцлага хүлээлгэнэ. Мөн улс төрийн шинжтэй мэдээлэлд маш болгоомжтой хандаж, бусдад түгээх эсвэл сэтгэгдлээ хурцаар илэрхийлэхээс татгалзах хэрэгтэй. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмаар цэргийн алба хаагчид байлдааны зэвсэглэлийн өмнө, анги, байгууллагын байрлалыг илэрхийлсэн эсвэл дүрмийн бус хувцасласнаас бусад тохиолдолд эмх цэгцтэй, цог золбоотой дүрэмт хувцастай гэрэл зургаа хувийнхаа цахим сүлжээнд байрлуулж болохоор тусгагдсан.

Гэсэн ч миний хувьд дүрэмт хувцас өөрөө таны бүх мэдээллийг багтаадаг учраас үүнээс татгалзах хэрэгтэй гэж зөвлөмөөр байна гэлээ. Тэрээр Зэвсэгт хүчний бүх алба хаагчид төрийн болон улсын нууцын жагсаалттай танилцах хэрэгтэй гээд саяхан батлагдсан энэхүү журам нь хориглохоос илүүтэй хамгаалах чиглэлтэй болохыг тодотголоо. Үүний дараа Хэвлэл мэдээллийн албаны дарга, хурандаа Б.Отгонбаяр Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд харьяа төрлийн цэргийн командлалын хэвлэлийн төлөөлөгчөөр дамжуулан сурталчилгааныхаа мэдээ мэдээллийг тогтмол ирүүлж байх, томилогдсон орон тооны бус хэвлэлийн төлөөлөгч нарыг чадваржуулахад Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын удирдлага анхаарч ажиллахыг захилаа. Ялангуяа, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Агаарын цэргийн командлалын нэгтгэл, ангиуд мэдээллээ ирүүлж хэвшсэн тухай онцлоод ЗХЖШ-ын веб сайт, “Соёмбо” редакцын “Соёмбо” сонин, “Дуулга” телестудийн мэдээ мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлгийг үздэг, уншдаг, бусдад түгээхэд цэргийн алба хаагчид идэвхтэй байх талаар онцолсон юм.

Ахлах дэслэгч Д.БОЛОР

ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН ХЭН ХЭЭРИЙН СУРГУУЛИЙГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Тусгай хүчний цэргийн командлал шинээр байгуулагдаж бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэнээс хойш анх удаа “2020-2021 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу харьяа нэгтгэл, ангиудтайгаа хээрийн гаралт, ротын байлдааны буудлагатай хээрийн сургуулийг 3 дугаар сарын 19-нөөс 4 дүгээр сарын 9-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулав.

Хээрийн гаралт, полигоны дадлагаар “Тусгай томилолтын бүлэг дайсны ар талд тагнуул, хорлон сүйтгэх ажиллагааг явуулах” /084/, “Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын салаа хот дотор давших” /150/, “Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын салаа ой тайгын уулархаг бүсэд давших” /330/, “Минометын тоотын галын дэмжлэгтэйгээр хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын салаа уулархаг бүсэд давших байлдааны ажиллагаа” /331/, “Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын рот тал, хээрийн нөхцөлд зах нийлсэн байдлаас давших” /150/, “Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын салаа зах нийлээгүй үед хориглолтод шилжиж, хориглох байлдааныг шөнө явуулах” /350/ сэдвүүдээр өдөр болон шөнийн буудлагыг тус тус явууллаа.

Салааны хоногийн сургуулийн үед салааны захирагч нар нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглан мэдээлэл олзворлож, шийдвэртээ тусгаж байсан зэрэг нь тус сургуулийн онцлог байлаа. Тусгай хүчний цэргийн хээрийн гаралт, полигоны дадлагын төгсгөлд ангиуд тус бүр байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг явуулсан юм. Тухайлбал, “Тусгай томилолтын бүлэг дайсны ар талд тагнуул, хорлон сүйтгэх ажиллагааг явуулах”, “Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын рот тал, хээрийн нөхцөлд зах нийлсэн байдлаас давших байлдааныг зохион байгуулах”, “Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын салаа уулархаг бүсэд давших байлдааныг явуулах”, “Мотобуудлагын салааны тактикийн бүлэг онцгой нөхцөлд давших байлдааныг явуулах”, “Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын рот зах нийлсэн байдлаас давшилтад шилжих” сэдвүүдээр харьяа ангиуд тус бүр ангийн үйл ажиллагаа, онцлогт тулгуурласан байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг амжилттай явуулсан юм.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 2	☁️ -9
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	☁️ 25
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 19	☁️ 7

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.845.00	2.856.00
EUR 🇪🇺	3.388.00	3.448.00
CNY 🇨🇳	434.50	437.90
RUB 🇷🇺	37.00	38.50
JPY 🇯🇵	25.90	26.40
KRW 🇰🇷	2.46	2.60

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 4
2021.04.16.
/БААСАН ГАРАГ/

**ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ
САРЫН НЭГ ЦАГААН ХӨХ
МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал:
Бие эрхтний хүч сайжирна.
Наран ургах, шингэх:
06.01-19.43
Барилдлага:
Шид
Шүтэн барилдлага:
Сэрэхүй
Суудал:
Төмөр.

Аргын тооллын 4 дүгээр сарын 16, Сугар гараг. Билгийн тооллын 4, Чөлөөт эх одтой, хөх морь өдөр. Өдрийн наран 6 цаг 01 минутад мандан, 19 цаг 43 минутад жаргана. Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвших, угаал үйлдэх, тангараг тавих, гэр бүрэхэд сайн. Хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 17.823+742	ЭДГЭРСЭН 10.638	НАС БАРСАН 31/6
НИЙТ БАТЛАГДСАН 1698 (8)	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 290	ЭДГЭРСЭН 1400

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 136,996,364
Эдгэрсэн Нийт: 111,605,138
Нас барсан Нийт: 2,951,832

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДҮН
2021.04.15

- 9 ЦЭГТ
- 16 БАГИЙН
- 125 АЖИЛТАН
- 60-ААС ДЭЭШ НАСНЫ ЗОРИЛТОТ БҮЛГИЙН 855 ИРГЭНИЙГ ДАРХЛААНУУЛАЛТАД ХАМРУУЛЛАА

УЛААНБААТАР ХОТЫН ХЭМЖЭЭНД
НИЙТ 496470 ХҮНИЙГ ДАРХЛААНУУЛАЛТАД ХАМРУУЛААД БАЙНА.

ЦАХИМ ШУУДАНД

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН АЛБАН ТУШААЛТНУУДЫГ СУРГАЛТАД ХАМРУУЛАВ



Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас ЗХЖШ, Зэвсэгт хүчний Төрийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан албан тушаалтнуудыг хамруулсан цахим сургалтыг энэ сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтыг Зэвсэгт хүчний хэмжээнд ажлын байрны эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, зэвсэглэл, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй байдлыг хангуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан албан тушаалтнуудын үүрэг хариуцлага, мэдлэг, ур чадварыг

дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж 54 албан тушаалтныг хамруулав. ЗХЖШ, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар, ХНХЯ, МХЕГ, ОБЕГ-ын улсын байцаагч, мэргэжилтнүүд, ХАБЭА-н сургалтын төвийн багш нар оролцсон уг сургалтаар 18 сэдвээр хичээлийг явуулсан нь цар тахлын үед цаг хугацаа, төсөв хөрөнгө хэмнэсэн, онолын мэдлэгийг богино хугацаанд олгосон үр дүнтэй сургалт боллоо. Сургалтын явцад болон төгсгөлд ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг биечлэн холбогдож, сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнд хандаж нэгтгэл, анги, байгууллагадаа

хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, сургалтаар олж авсан мэдлэгээ анги, байгууллага, бие бүрэлдэхүүндээ түгээх, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээрх сургалтыг тасралтгүй зохион байгуулж, осол зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар үүрэг чиглэл өгч, ажлын амжилт хүссэн юм. Цаашид Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас хяналт шалгалтын чиглэл тус бүрээр төрөл бүрийн богино хугацааны сургалтыг цахим хэлбэрээр явуулахаар төлөвлөж байна.

Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Хугацаат цэргийн алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие даан хөгжихөд нь туслах зорилгоор англи хэл, уран зураг, гитарын дугуйлан хичээллүүлэхээр бэлтгэл ажлаа бүрэн хангалаа.

Хамгийн сонирхолтой нь дугуйлангуудын сургагч багшаар хугацаат цэргийн алба хаагчид ажиллах юм. Тухайлбал, англи хэлний багшаар байлдагч Э.Золбаяр ажиллах бөгөөд тэрээр МУБИС-д англи хэлний багш мэргэжлээр суралцдаг. Уран зургийн багшаар МУБИС-д дүрслэх урлагийн багш мэргэжлээр суралцдаг байлдагч С.Бат-Эрдэнэ, гитарын багшаар ахлах байлдагч Б.Золбоо нар ажиллана.

Хугацаат албаны дайчид нэгнээсээ суралцаж, нэгэндээ зааж зааварлах нь нөхөрлөлийг бататгах, суралцах хүсэл эрмэлзлэлийг нь нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой гэж ангийн удирдлагууд үзэж байгаа юм. Тийм ч учраас дугуйлангуудыг хичээллүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, зарим хэрэгслийг сургагч багш нарт гардуулан өгч, амжилт хүслээ.

Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР

ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧИД НЭГНЭЭСЭЭ СУРАЛЦАНА



ХОВДЫН ХОРОО ЦАХИМ УУЛЗАЛТ ХИЙВ



Зэвсэгт хүчний 123 дугаар анги


Батлан хамгаалах салбарын эрх зүйн шинэчлэлийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлан таниулах, цар тахлын халдвар гарсантай холбогдуулан хугацаат цэргийн алба хаагчдаа ар гэрийнхэнтэй нь утсан холбоо болон

интернэтээр тогтмол хугацаанд "уулзуулж" байгаа билээ. Энэ удаад Баян-Өлгий аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран тус аймгаас татагдан ирсэн дайчдыг ар гэрийнхэнтэй нь интернэтээр холбох ажлыг зохион байгуулав. Энэ үеэр дайчдын ар гэрийнхэнд Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч,

хурандаа Х.Энхболд мэндчилгээ дэвшүүлж, алба хааж байгаа дайчдад Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Нацагдорж орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баярын мэнд хүргэж, цэргийн алба нэр төртэй үлгэр жишээчээр хаахыг захисан юм.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ

ЭР ЦЭРГИЙН АЛБАА НЭР ТӨРТЭЙ ХААЖ БАЙГАА ХҮҮГЭЭРЭЭ БИД БАХАРХАЖ БАЙНА



Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Тус дүүргээс Зэвсэгт хүчний ангиудад алба хааж буй хугацаат цэргийн алба хаагчдыг ар гэрийнхэнтэй нь утсаар болон цахимаар холбох ажлыг зохион байгууллаа. Энэ үеэр дайчдын ар гэрийнхний "Бид сайн байгаа. Миний хүү эх орны хүү болжээ. Ар гэртээ санаа зоволтгүй. Олон

аавын хүүхдүүдтэй эвтэй найртай байж, эр цэргийн алба нэр төртэй хаагаад ирээрэй. Албаа нэр төртэй хааж байгаа хүүгээрээ бид бахархаж байна" хэмээх урмын үг бүхий яриагаар уулзалт өрнөсөн бол хугацаат цэргийн алба хаагчдын зүгээс хүүдээ санаа зовох хэрэггүй. Албаа сайн хааж байгаа гэдгээ илэрхийлж байлаа.

Ахлах дэслэгч Б.БАТЦЭЦЭГ

ТӨГСГӨЛИЙН ШАЛГАЛТ ХЭРХЭН ЯВАГДАХ ВЭ

Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу үндсэн салбарын жигдрэлтийн шатны сургалт бэлтгэл амжилттай зохион байгуулагдаж нэгтгэл, ангийн захирагчийн нэрэмжит төгсгөлийн шалгалт явагдаж байна.

Энэхүү шалгалтыг зохион байгуулахдаа нэгтгэл, ангиуд ЗХЖШ-ын даргын 2017 оны А/500 дугаар тушаалаар батлагдсан "Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийг шалгаж, үнэлэх заавар"-ыг удирдлага болгон бие бүрэлдэхүүний бэлтгэлжилт, штабын бэлтгэл сургалтын түвшин, салбарын бэлтгэл, жигдрэлтийг шалгаж үнэлнэ.

Бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн түвшинг тухайн сургуулийн жилд судалсан хичээлийнхөтөлбөрийнагуулгын хүрээнд байнгын бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн алба хаагч гэсэн ангиллаар нийт бие бүрэлдэхүүний мэдлэг, боловсролын түвшин, мэргэжил, ур чадварын түвшин, сэтгэл зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг нь тус тус шалгаж үнэлэх юм.

Штабын бэлтгэл, сургалтын түвшинг ЗХЖШ-ын 2020 оны А/640 дүгээр тушаалаар батлагдсан "Штабын бэлтгэлийг зохион байгуулах заавар"-ын хүрээнд зохион байгуулна. Ингэхдээ офицеруудын даргын бэлтгэлийг тактикийн шуурхай дадлагаар, штабын жигдрэлтийн түвшинг нэгтгэл, ангиуд ТЦОТ-ны хүч хэрэгслээр байлдааны үүрэг гүйцэтгэх бодит боломжид нийцүүлэн ажиллагааны хувилбар, захирагчийн шийдвэрийг боловсруулах асуудлаар штабын нэгдсэн дадлага /КШС/-аар тус тус шалгаж үнэлнэ.

Салбарын бэлтгэл, жигдрэлтийг тасаг /тоот/-ийн, салааны болон үндсэн салбар, түүнтэй адилтгах нэгжийн түвшинд шалгаж үнэлэх бөгөөд цэргийн сургалт бэлтгэлийн удирдлага, зохион байгуулалт, материаллаг нөөцийн байдлаа "Цэргийн сургалт бэлтгэлийг шалгаж, үнэлэх заавар"-ын 4.3.7-д заасны дагуу үнэлж дүгнэнэ.

Шалгалтын актад дараах зүйлийг зайлшгүй тусгана. Үүнд: -Төгсгөлийн шалгалтын зохион байгуулалт; -Хүн нэг бүрийн бэлтгэлийн зохион байгуулалт, үр дүн; -Штабын бэлтгэл, жигдрэлтийн зохион байгуулалт, үр дүн;

-Анги, салбарын жигдрэлтийн зохион байгуулалт, үр дүн; -Цэргийн сургалт бэлтгэлийн удирдлага, зохион байгуулалт, сургалтын материаллаг бааз, санаачлан хийсэн ажил зэрэг үндсэн асуудлыг тусгаж, төгсгөлд нь дүгнэлт, ололт, дутагдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, байлдааны дүрэм, заавруудад оруулах нэмэлт өөрчлөлт болон удирдлагын байгууллагуудаар шийдвэрлүүлэх санал, асуудлуудыг тусгана.

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд төгсгөлийн шалгалтын дүнг цэргийн сургалт бэлтгэлийн дүнгийн 1-5 дугаар маягтаар нэгтгэн, шалгалтын актын хамт харьяа Төрийн цэргийн командлал, Удирдах газар, командлал, газар, хэлтсүүд нэгдсэн дүн, актаа, санал, дүгнэлтийн хамт 2021 оны 4 дүгээр сарын 30-ны дотор ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтэст ирүүлнэ.

Дэд хурандаа Н.БАТСАЙХАН